



ӨВӨРХАНГАЙ
АЙМГИЙН ӨЛЗИЙТ
СУМЫН АЙМГИЙН
ТЭРГҮҮНИЙ ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГ

СӨББАЙГУУЛЛАГА



1960 онд
“Сангийн далай
хүүхдийн цэцэрлэг”
нэртэйгээр “Оч”
нэгдлийн төвд
байгуулагдсан.

Эрхэм зорилго:

**Хүүхэд бүрт
урам хайрлая**

**Хүн бүрт итгэл
төрүүлье**

**Хамт олноороо
шийдэлд хүрье.**

Алсын хараа:

**Мэргэжлээрээ
хөрвөж ажиллах
чадварлаг багш,
ажиллагсадаар
хангагдаж,
сургуулийн өмнөх
боловсролыг чанар
хүртээмжтэй явуулж,
эцэг эх, иргэдийн
талархлыг хүлээсэн
байгууллага болно.**

**Хөөрч байрлах нь
хүүхэд шиг амархан
Хөнгөн гуних нь хүүхэд
шиг гэгээхэн
Өнгө, мөнгөний
хорвоогоос илүү зүйл
хүсээгүй
Өр нимгэн сэтгэлээ
хүний үрээс ч
харамлаагүй
Цэцэрлэгийн багш
даруухан алба .**

**Өвөрхангай аймгийн
Өлзийт сумын
“Аймгийн тэргүүний”
хүүхдийн цэцэрлэгт
ажиллаж байсан үе
үеийн эрхлэгч нар.**

**Анхны эрхлэгч
Ё.Норжин нь 1951 онд
Өвөрхангай аймгийн
Өлзийт сумын
Гуулингийн бригадад
төрсөн. 1959- 1963
онд Өлзийт сумын
бага сургууль,
Хужирт сумын дунд
сургуулийг төгссөн.**



**Л.Должмаа
Эрхлэгч**

**Лхасүрэн овогтой
Должмаа нь 1949 онд
Баянхонгор аймгийн
Галуут суманд төрсөн.
1968 онд хүмүүжүүлэгч
багш мэргэжлээр төгсөж
тус цэцэрлэгт эрхлэгч,
багшаар 1968-1970 онд
ажиллаж байсан.**



Ж.Дэнсмаа
Эрхлэгч

**Жумдаан овогтой
Дэнсмаа нь
Өвөрхангай аймгийн
Өлзийт суманд
төрсөн. 1971-1973
онд эрхлэгчээр
ажиллаж байсан.**



П.Лхагва
Эрхлэгч

**Пэрэнлэй овогтой Лхагва нь
Өвөрхангай аймгийн Өлзийт
суманд төрсөн. 1970-1974 онд
Улаанбаатар хотын Цэцэрлэгийн
багшийн сургуулийг төгсөж
ирээд Хүүхдийн цэцэрлэгт 1974-
1977 онд хүмүүжүүлэгч багшаар
1981-1988 онд эрхлэгчээр
ажиллаж байсан. Боловсролын
тэргүүний ажилтан.**



**Б.Дашмаа
Эрхлэгч**

Б.Дашмаа нь 1946 онд Өвөрхангай аймагт төрсөн. 1965 онд Улаанбаатар хотын Цэцэрлэгийн багшийн сургууль төгссөн. 1978- 1980 онд Өлзийт сумын цэцэрлэгт багш, эрхлэгчээр ажиллаж байсан.



**Г.Хишигжаргал
Эрхлэгч**

Галдан овогтой Хишигжаргал нь 1965 онд Өвөрхангай аймгийн Өлзийт суманд төрсөн. Улаанбаатар хотын Цэцэрлэгийн багшийн сургууль, Отгонтэнгэр Их сургуулийг тус тус төгссөн. 1985- 2022 онд Өлзийт сумын цэцэрлэгт багш, эрхлэгчээр ажиллаж байсан Монгол Улсын Тэргүүлэх зэрэгтэй, “Боловсролын тэргүүний ажилтан”, “Хөдөлмөрийн хүндэт” тэмдэг, Аймгийн тэргүүний СӨББ- ын эрхлэгч, Сумын “Тэргүүний сэхээтэн”



Д.Амарсанаа Эрхлэгч

Доржсорог овогтой Амарсанаа нь Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд төрсөн. МУБИС-СӨБСургуулийг төгссөн. Арвайхээр сумын Улсын Тэргүүний 4 дүгээр цэцэрлэгт багшаар ажиллаж байсан Одоо Өлзийт сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байна. Монгол Улсын Тэргүүлэх зэрэгтэй , “Боловсролын тэргүүний ажилтан”



ӨРГӨМЖЛӨЛ



ӨЛЗИЙТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ХАМТ ОЛОНД

Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж, жилийн үйл ажиллагааны үр дүнгээр 2016 оны “Тэргүүний байгууллага”-аар шалгарсан тул “Өргөмжлөл” хадгалуулж, мөнгөн шагналаар шагнав.

Танай хамт олонд ололт, амжилтаа бататган, үлгэрлэн манлайлж ажиллахыг хүсэн ерөөе.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН

ЗАСАГ ДАРГА  Г.ГАНБОЛД

Арвайхээр хот

2017.02.15

1960 онд “Сангийн далайн хүүхдийн цэцэрлэг” нэртэйгээр Оч нэгдлийн хөрөнгөн дээр тулгуурлан ясли, цэцэрлэгийн насны 15 хүүхэдтэй 1 хүмүүжүүлэгч, багштай улирлын чанартайгаар байгуулагдсан түүхтэй.

Анхны хүмүүжүүлэгч багшаар Г. Норжин , Н.Сугарсүрэн Буяндэлгэр нарын хүмүүс ажиллаж байжээ.

1968 оны 8 дугаар сараас эхлэн 30 хүүхэд, хүмүүжүүлэгч багш, асрагч, нярав, тогооч зэрэг орон тоотой байнгын ажиллагаатай цэцэрлэг болсон. Энэ үед 3 өрөөтэй цэцэрлэгийн модон барилгыг нэгдлийн төлөө бригадын гишүүдийн хүчээр баригдаж ашиглалтанд оруулжээ.

1969-1970 оны хичээлийн жилээс эхлэн улсын төсвөөр үйл ажиллагаагаа явуулж мэргэжлийн боловсон хүчинтэй болсон байна. Цэцэрлэгийн багшийн сургуулийг Л.Должмаа багш төгсөж ирээд анхны мэргэжлийн багшаар ажиллаж, асрагч няраваар Ч.Чанцал, тогоочоор Р.Хорлоо нар хамтран ажиллаж байжээ.

1976 онд сумын төв Хүйсийн голд нүүн ирж төвлөрөхөд 50 хүүхдийн тоглоом сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан. Жилдээ 50 хүүхэд хүлээн авчсургалт хүмүүжлийн ажлыг явуулдаг. Байгууллагын бүтэцийн хувьд 2 багш, нийт 10 орон тоотой жилдээ улсаас 35- 45 сая төгрөгийн төсөвтэй ажилладаг болсон байна.

ӨЛЗИЙТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГТ АЖИЛЛАЖ БАЙСАН ҮЕ ҮЕИЙН БАГШ АЖИЛЧИД



Арын эгнээний баруун гар талаас
П.Пүрэвдавга, П.Лхагва,
И.Эрдэнэчимэг, Б.Магсаржав,
Г.Хишигжаргал
урд эгнээний баруун гар талаас |
П. Жаргал, В.Сангидорж, Б.Сумъяа





Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын амжилтуудаас

- ❖ 2003, 2006 онд “Сумын аварга” байгууллага
- ❖ 2005 онд Өвөрхангай аймгийн цэцэрлэгүүдээс сүүлийн 2 жил дараалан 5 –р байрт, Зүүн соёмбо бүсийн цэцэрлэгүүдээс 1 –р байранд шалгарсан .
- ❖ 2012 онд “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” ын болзлыг амжилттай биелүүлж “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ын БАТЛАМЖ 1,2,3-р зэргийг авсан.
- ❖ Сумын “Тэргүүний байгууллага” –аар 12 удаа шалгарсан
- ❖ 2016 онд “Аймгийн тэргүүний байгууллага”уаар шалгарсан.

Өвөрхангай аймгийн
өлзийт сумын “Аймгийн
тэргүүний” хүүхдийн
цэцэрлэг нь эрхлэгч,
бүлгийн багш 2, туслах
багш 2, нярав 1, тогооч 2,
үйлчлэгч 1, сахиул 1 гэх
мэт 10 хүний орон
тооны бүрэлдэнүүнтэй
үйл ажиллагаа хэвийн
явуулж байна. Үүнээс
Монгол улсын Тэргүүлэх
зэрэгтэй 2, Заах аргач
зэрэгтэй 1 багш байна.



*2016 оны Өвөрхангай аймгийн
аварга "Тэргүүний байгууллага"-
аар шалгарав.*



“Ангаахай” бүлэг



**Бүлгийн багш С.Цэрэнханд
/Заах аргач /**

Туслах багш Х.Мөнхнасан







“Дэгдээхий” бүлэг



Бүлгийн багш Д.Наваантуяа
/Монгол Улсын Тэргүүлэх/
“Боловсролын тэргүүний
ажилтан”
Туслах багш Б.Дуламсүрэн







Ахлах тогооч Г.Долгорсүрэн
Худалдаа үйлдвэрлэлийн тэргүүний ажилчин



Үйлчлэгч Д.Тунгалаг



Сахиул Э.Лхагва
“Эрчим хүчний тэргүүний” ажилтан







Зуны сургалт - 2022.06.11







*Эрдэнэт хүмүүний
эгэлгүй бахархал
Эрхмийн дээд
багш минь та
Энэхэн биеийг минь
эрдмээр чимж
Энгүй амьдралын далайд
залуур болсон ачтан*

2022.10.27

